

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Усны тоо бүртгэл явуулах журам"-ыг нэгдүгээр, "Усны тоо бүртгэлийн мэдээлэл бүрдүүлэх заавар"-ыг хоёрдугаар, "Усны тоо бүртгэлийн мэдээлэл бүрдүүлэх, нэгтгэл хийх маягт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Усны сав газрын захиргаад болон аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дарга нарт даалгаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Усны газар /З.Батбаяр/-т үүрэг болгосугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Байгаль орчны сайдын 2006 оны 269 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.БАТ-ЭРДЭНЭ

## **УСНЫ ТОО БҮРТГЭЛ ЯВУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь усны тоо бүртгэл явуулах, усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн тоо, хэмжээ, чанар, ашигласан болон хаягдал усны хэмжээ, усны барилга байгууламжийн ашиглалтын талаарх мэдээллийг бүрдүүлэх, Улсын усны мэдээллийн сангийн бүрдлийг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Усны тоо бүртгэл явуулахад Усны тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам, Улсын усны мэдээллийн сангийн бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулна.

1.4. Сав газрын захиргаа нь сав газрын хэмжээнд усны тоо бүртгэлийг хамрагдах сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн байгаль орчны газартай хамтран зохион байгуулна.

### **Хоёр. Бүрдүүлэх мэдээ, мэдээлэл**

2.1. Усны тоо бүртгэлийн хүрээнд бүрдүүлэх мэдээ, мэдээлэл нь улсын усны мэдээллийн сангийн бүрдлийг хангах бөгөөд дараах мэдээллийг бүрдүүлнэ. Үүнд:

2.1.1. Усны сан бүхий газрын мэдээлэл (гол горхи, булаг шанд, рашаан, нуур тойром, баянбүрд, мөстөл, мөсөн гол, хиймэл нуур, хөв цөөрмийн байршил, устай эсэх төлөв байдал, усны түвшиний өөрчлөлт, эхийг нь хашиж хамгаалах шаардлагатай эсэх, хамгаалалтын бүс тогтоосон эсэх, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ордог эсэх, ашиглалтын байдал, хамрагдах сав газар);

2.1.2. Нөөц нь батлагдсан болон судалгаа хийгдсэн газрын доорх усны орд, рашааны ордын мэдээлэл (батлагдсан болон ашиглах боломжит нөөцийн хэмжээ, чанар, ашиглалт, хамгаалалтын байдал);

2.1.3. Ус хангамжийн эх үүсвэрийн мэдээлэл (сум, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж буй худаг, ус түгээх байрны байршил, зориулалт, техникийн үзүүлэлт, техникийн баримт бичиг, ус ашиглалт, хэрэглэгчийн тоо, хамгаалалтын хашаа, эрүүл ахуйн бүс тогтоосон эсэх, тоолууртай эсэх, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ордог эсэх, ашиглалтын байдал, хамрагдах сав газар);

2.1.4. Усны барилга байгууламжийн мэдээлэл (худаг, хяналт-шинжилгээний цооног, услалтын систем, үерийн хамгаалалтын далан, суваг, усан цахилгаан станц, цэвэрлэх байгууламжийн байршил, төрөл, зориулалт, техникийн үзүүлэлт, техникийн баримт бичиг, хүчин чадал, ус ашиглалт, хэрэглэгчийн тоо, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ордог эсэх, ашиглалтын байдал, хамрагдах сав газар);

2.1.5. Ус ашиглалтын мэдээлэл (ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл, ус ашиглалтын төрөл, зориулалт, ашигласан усны хэмжээ, усны хэмнэлт, эргүүлэн ашиглалт, төлбөр хураамж төлөлт, хөнгөлөлт);

2.1.6. Ус бохирдуулагч эх үүсвэрийн мэдээлэл (байршил, үйлдвэр, үйлчилгээний төрөл, хаягдал усны хэмжээ, чанар найрлага, хаягдлын цэг, ашиглаж буй технологи, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ордог эсэх, ашиглалтын байдал, хамрагдах сав газар);

### **Гурав. Усны тоо бүртгэл явуулах эрх бүхий байгууллагуудын оролцоо**

3.1. Усны тоо бүртгэл явуулахад шаардагдах төсвийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-ийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.2.1 дахь заалтыг үндэслэл болгон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах ажлыг сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн байгаль орчны газар хариуцан зохион байгуулна.

3.2. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан төсвийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга Усны сав газрын захиргаатай байгуулсан гэрээний үндсэн дээр усны тоо бүртгэлийн ажлыг гүйцэтгүүлж болно.

3.3. Усны тоо бүртгэлийн ажлыг сум, дүүргийн ЗДТГ, аймаг, нийслэлийн байгаль орчны газар, усны сав газрын оролцоотой хамтарсан ажлын хэсэг байгуулан гүйцэтгэж болно.

3.4. Сав газрын захиргаа нь сав газарт хамрагдах сум, дүүргийн нутаг дэвсгэрт усны тоо бүртгэлийн ажлыг дангаар ажлын хэсэг байгуулан гүйцэтгэж болох бөгөөд орон нутагт ажиллахдаа ажлын зорилго, ажиллах хугацаа, гүйцэтгэх арга хэмжээний талаар нутгийн захиргааны байгууллагад танилцуулж, харилцан мэдээлэл солилцох үүрэг хүлээнэ.

3.5. Сум, дүүргийн Засаг дарга нь сав газрын захиргаанаас байгуулагдсан ажлын хэсгийг холбогдох мэдээллээр хангаж, шаардлагатай мэргэжилтэнг томилон, хамтарч ажиллана.

3.6. Аймаг, нийслэлийн байгаль орчны газар, усны сав газрын захиргаа нь сум, дүүргийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийг усны тоо бүртгэл явуулах, холбогдох мэдээ, мэдээллийг бүрдүүлэх аргазүйгээр хангана.

3.7. Хэд хэдэн сав газарт хуваагддаг сум, дүүргийн усны тоо бүртгэлийн ажлыг тухайн сум, дүүргийн Засаг даргатай харилцан тохиролцсоны үндсэн дээр газар нутгийн ихэнх хэсгийг нь эзэлдэг эсвэл газарзүйн байрлалын хувьд хүрч ажиллах илүү боломжтой сав газрын захиргаа хариуцан сум, дүүргийн нэгдсэн мэдээллийг бүрдүүлж, суурин боловсруулалтын ажлын хүрээнд хамрагдах сав газрын хилээр ангилна.

### **Дөрөв. Усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах, мэдээлэл бүрдүүлэх**

4.1. Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой мэдээллийг жил бүр батлагдсан маягтын дагуу гаргаж сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хамрагдах Усны сав газрын захиргаанд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.2. Сум, дүүргийн усны асуудал хариуцсан мэргэжилтэн энэ журмын 2.1.4, 2.1.5-д заасан мэдээллийг сум, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан, мэдээллийг нэгтгэж, үнэн зөв эсэхэд хяналт тавьж ажиллана.

4.3. Аймаг, нийслэлийн байгаль орчны газар, Усны сав газрын захиргаа нь энэ журмын 2.1.4, 2.1.5-д заасан мэдээллийг сум, дүүргийн ус ашиглалтын мэдээлэл болон ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрлийн мэдээлэлд тулгуурлан гаргана.

4.4. Аймаг, нийслэлийн байгаль орчны газар, Усны сав газрын захиргаа нь усны тоо бүртгэлийн мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавин Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээллийг маягтаар болон цахимаар хүргүүлнэ.

4.4. Энэ журмын 2.1.1, 2.1.3, 2.1.4-д заасан мэдээллийг газар дээр нь очиж, батлагдсан маягтын дагуу бүртгэл хийнэ.

4.5. Энэ журмын 2.1.2-д заасан мэдээллийг тухайн ордын судалгааны тайлан, мэдээлэлд үндэслэн гаргана.

4.6. Энэ журмын 2.1.1, 2.1.3, 2.1.4, 2.1.6 заасан мэдээлэл дэх хөдөлгөөнгүй цэгийн координатын фото мониторингийн мэдээллээр усны тоо бүртгэлийг баяжуулан, харьцуулалт хийнэ.

4.6. Усны тоо бүртгэлийн ажилд Монгол орны нутаг дэвсгэрийн 1:25'000, 1:50'000, 1:100'000 масштабтай байр зүйн зураг, Улсын геодези, зураг зүйн газраас (хуучин нэрээр) 1983-1985 онд боловсруулж гаргасан сумдын газар нутгийн нэрийн зургийг ашиглан гол горхи, нуур тойром, булаг шанд, рашааны нэрийг батлагдсан суурь зургийн мэдээлэлтэй тулгаж, шаардлагатай тохиолдолд нэр, нэршлийг өөрчилөн, газар нутгийн нэрээр баяжуулж бүртгэнэ.

4.7. Худаг, бусад усны барилга байгууламжийг байр зүйн болон газар нутгийн нэрийн зураг ашиглан нэмэлт тодруулга хийж, газар нутгийн нэрээр бүртгэнэ.

4.8. Усны тоо бүртгэлийн хүрээнд бүрдүүлэх зарим мэдээллийг сансарын зураг, газарзүйн мэдээллийн системийн программ хангамж ашиглан бүрдүүлж болно.

4.9. Энэ журмын 4.7-д заасан арга аргачлалаар мэдээлэл бүрдүүлсэн тохиолдолд тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт тодорхой цэгүүдэд газар дээр нь очиж баталгаажуулалт хийнэ.

4.10. Усны тоо бүртгэлийн мэдээллийг баталсан маягтын дагуу үзүүлэлт тус бүрээр сум, дүүрэг, аймаг, нийслэл, сав газрын хэмжээнд дэлгэрэнгүй болон нэгдсэн тоон мэдээллийг гаргана.

4.11. Усны тоо бүртгэлийн хүрээнд цуглуулсан мэдээ, мэдээллийг нэгтгэн сум, дүүрэг, аймаг, нийслэл, сав газрын ус зүйн зургийг аймаг, нийслэлийн байгаль орчны газар, сав газрын захиргаа хариуцан боловсруулна.

### **Тав. Усны тоо бүртгэл явуулах, тайлагнах хугацаа**

5.1. Усны тоо бүртгэлийг сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн жилийн 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, тогтоосон журам, батлагдсан маягтын дагуу мэдээ, мэдээллийг бүрдүүлж, сум, дүүргийн усны тоо бүртгэлийн тайлан болон аймаг, нийслэл, Усны сав газрын усны тоо бүртгэлийн нэгдсэн тайланг боловсруулна.

5.2. Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 2.1.1 – 2.1.6-д заасан мэдээ, мэдээллийг нэгтгэн жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, хамрагдах сав газрын захиргаанд;

5.3. Аймаг, нийслэлийн байгаль орчны газар нь сум, дүүргийн усны тоо бүртгэлийн мэдээ, мэдээллийг нэгтгэж, нэгдсэн тайланг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хамаарах Сав газрын захиргаа болон усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад;

5.4. Сав газрын захиргаа нь аймаг, нийслэлийн байгаль орчны газраас ирүүлсэн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулсан усны тоо бүртгэлийн мэдээ, тайланг сав газрын хэмжээнд нэгтгэн жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хэвлэмэл байдлаар болон цахимаар хүргүүлж, улсын усны мэдээллийн санд төвлөрүүлнэ.

5.5. Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Сав газрын захиргаадаас ирүүлсэн мэдээ тайланд хяналт хийх, нэгтгэх ажлыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулж Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээллэх;

---o0o---

## **УСНЫ ТОО БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР**

### **Ерөнхий аргачлал**

1. Усны тоо бүртгэлийн хээрийн судалгааны ажил гүйцэтгэхэд Монгол орны нутаг дэвсгэрийн 1:25'000, 1:50'000, 1:100'000 масштабтай байр зүйн зураг, тухайн сумын газар нутгийн нэрийн зургийг ашиглан, зурагт тэмдэглэгдсэн усны сан бүхий газар, худаг, усны барилга байгууламжийн нэр нэршил, байрзүйн мэдээллийг тулгаж, газар нутгийн нэрээр баяжуулан, суурь мэдээлэл бүрдүүлэх ажлыг зайлшгүй хийнэ.
2. Байршил тогтоогч багажны тохиргоонд WGS 84 солбицлын системийг сонгож, координатыг градус, минут, секундын нарийвчлалтайгаар тохируулж ашиглана.
3. Усны тоо бүртгэлд ашиглаж буй усны чанар болон бусад үзүүлэлт тодорхойлох багаж төхөөрөмжийг Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулсан байна.
4. Усны тоо бүртгэлийн маягтын сонгох хэсэг дэх мэдээллийг заавал сонгож, байршил, төрөл, ус зүйн төлөв байдал, ашиглалт, хамгаалалтын байдал зэрэг нарийвчилсан тоон мэдээллийг үзүүлэлт бүрээр гаргана.

### **Усны сан бүхий газрын бүртгэл:**

1. Тухайн усны сан бүхий газар нь хэд хэдэн сум, дүүргийн хил дамнан байрладаг бол тухайн сум, дүүрэг тус бүрт бүртгэж, аймаг, нийслэлийн нэгтгэл гаргахад давхардсан тоог хасаж гаргана.
2. Усны сан бүхий газрын устай эсэх төлвийг өмнөх жилийн ус зүйн төлөвтэй харьцуулж бүртгэнэ.
3. Гол горхи, булаг шанд, рашааныг горимын хувьд байнгын, түр зуурын урсацтай гэж ангилна.
4. Гол горхи, булаг шанд, рашааныг 4 жилийн турш усгүй байсан бол “ширгэсэн” ангилалд, тухайн жилдээ усгүй байгаа бол гол горхийг тасарсан, булаг шанд, рашааныг “усгүй”, өмнөх жил усгүй байгаад тухайн жилд устай болсон бол гол горхи, булаг шанд, рашааныг “сэргэсэн” ангилалд, дараа жил нь устай бол “устай” ангилалд шилжүүлж бүртгэнэ.
5. Нуур тойром, баянбүрд, хөв цөөрмийг тухайн жилдээ усгүй бол “ширгэсэн”, өмнөх жил усгүй байгаад дараа жил устай болсон бол “сэргэсэн”, түүний дараа жил нь устай байвал “устай” ангилалд шилжүүлж бүртгэнэ.
6. Нуур тойром, баянбүрд, хөв цөөрмийн усан мандлын талбайн хэмжээг өмнөх жилийнхтэй харьцуулж усан мандлын талбай нэмэгдсэн, хэвийн, багассан, эрс багассан зэргээр ангилна.
7. Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоосон эсэх мэдээллийг тодруулж, хамгаалалтын бүс тогтоосон шийдвэрийн нэр, огноог бүртгэлд оруулна.
8. Тухайн усны сан бүхий газар нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт орж байгаа бол хамгаалалтын бүс тогтоосон гэж үзнэ.
9. Гол горхи, булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалах шаардлагатай эсэх, хамгаалалтын хашаа хайсыг засаж сэлбэх шаардлагатай эсэхийг тодруулна.
10. Усны сан бүхий газрын усны горим (урсгалын хурд, өнгөрөлт, ундарга гэх мэт), дүрс зүйн үзүүлэлт (урт, өргөн, талбай гэх мэт), усны чанарын үзүүлэлтүүдийг боломжтой

цэгүүдэд тодорхойлж, дараагийн жилүүдэд тухайн цэгт болон бусад цэгүүдэд тодруулга хийх замаар сум, дүүргийн хэмжээний суурь мэдээлэл бүрдүүлнэ.

#### **Усны барилга байгууламжийн бүртгэл:**

1. Сум, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа худаг, ус түгээх байрны байршил, зориулалт, техникийн үзүүлэлт, ус ашиглалт, хэрэглэгчийн тоо, хамгаалалтын хашаа, эрүүл ахуйн бүс тогтоосон эсэх, тоолууртай эсэх, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ордог эсэх, ашиглалтын байдал, хамрагдах сав газрыг тус тус тодруулж бүртгэнэ.

2. Худгийг төрлөөр нь ерөмдмөл, гар (богино яндант, бетонон хашилгагч, энгийн уурхайн) гэж ангилж бүртгэнэ.

3. Тухайн худагт эрүүл ахуйн бүс тогтоосон эсэх, усны тоолуур суурилуулсан эсэх, ажилладаг эсэх, паспорттой эсэх, ус ашиглалт, хэрэглээний зориулалт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэл, барилгатай эсэх, барилгын хийц, ерөмдсөн байгууллага, худгийн гүн, ундрага, усны чанар, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр, холбогдох хаяг, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газарт хамрагдаж байгаа эсэх зэрэг мэдээллийг тодруулна.

4. Тухайн ус хангамжийн эх үүсвэр, худаг, усны барилга байгууламж нь сум, дүүргийн хил дамнан байрладаг бол тухайн сум, дүүрэг тус бүрт бүртгэж, аймаг, нийслэлийн нэгтгэл гаргахад давхардсан тоог хасаж гаргана.

5. Ус хангамжийн эх үүсвэр, бусад худгийн усны чанарын мэдээллийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, эсвэл хээрийн судалгааны ажлын явцад хийсэн чанарын хэмжилтийн үр дүнгээр бүрдүүлнэ.

6. Хяналт-шинжилгээний цооног, усалалтын систем, үерийн хамгаалалтын далан, суваг, усан цахилгаан станц, цэвэрлэх байгууламж зэрэг усны барилга байгууламжийн байршил, төрөл, зориулалт, техникийн үзүүлэлт, хүчин чадал, ус ашиглалтын хэмжээ, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ордог эсэх, ашиглалтын байдал, хамрагдах сав газар зэрэг мэдээллийг тодруулна.

#### **Ус ашиглалтын бүртгэл:**

1. Ус ашиглалтын төрлөөс хамааруулж ус ашиглагч, хэрэглэгч гэсэн ангиллаар бүртгэл хийнэ.

2. Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл, ус хангамжийн эх үүсвэр, ус ашиглалтын төрөл, зориулалт, ашигласан усны хэмжээ, усны хэмнэлт, эргүүлэн ашиглалт, усны нөөц ашигласны төлбөр төлөлт, хөнгөлөлт зэрэг мэдээллийг бүрдүүлнэ.

#### **Ус бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл:**

1. Ус бохирдуулагч эх үүсвэрийн байршил, эрхэлж буй үйлдвэр, үйлчилгээний төрөл, хаягдал усны хэмжээ, чанар найрлага, хаягдлын цэгийн байршил, ашиглаж буй технологи, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт ордог эсэх, хамрагдах сав газар зэрэг мэдээллийг бүрдүүлнэ.

2. Хаягдал усаа хаана хаядаг, стандартын шаардлага хангадаг эсэх, төлбөр хураамж, хаягдал ус зайлуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрлийн талаарх мэдээллийг бүрдүүлнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын  
Сайдын 2023 оны ... дүгээр сарын ... -ны өдрийн  
А-... тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Маягт А-01. Нуур, тойрмын бүртгэл

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- СОНГОХ --	-- СОНГОХ --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Нуурын нэр
-- СОНГОХ --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Давхардаж тоологддог эсэх	Ангилал
	-- СОНГОХ --	
Төрөл	Нуураас эх авсан гол	Нуурт цутгаж буй гол
Усан мандлын талбай м <sup>2</sup>	Түвшний өөрчлөлт	Устай эсэх төлөв (Өмнөх онд)
		-- СОНГОХ --
Устай эсэх төлөв (Тухайн онд)	рН	DO мг/л
-- СОНГОХ --		
EC, µS/cm	TDS, мг/л	t°С
Урт, м	Өргөн, м/с	Дундаж гүн, м
Дүрсзүйн хэлбэр	Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх	Шийдвэр, огноо
	-- СОНГОХ --	
Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо	Тайлбар
-- СОНГОХ --		
Хамрагдах сав газрын нэр		
-- СОНГОХ --		



Маягт А-02. Гол, горхины бүртгэл

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- СОНГОХ --	-- СОНГОХ --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Голын нэр
-- СОНГОХ --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Давхардаж тоологддог эсэх	Тухайн голд цутгаж буй голын нэр
	-- СОНГОХ --	
Хаана цутгах	Урсацын горим	Устай эсэх төлөв (Өмнөх онд)
	-- СОНГОХ --	-- СОНГОХ --
Устай эсэх төлөв (Тухайн онд)	pH	DO мг/л
-- СОНГОХ --		
EC, $\mu\text{S}/\text{cm}$	TDS, мг/л	t <sup>0</sup> C
Дундаж өргөн, м	Урсгалын хурд, м/с	Дундаж гүн, м
Өнгөрөлт, м <sup>3</sup> /с	Харуулын нэр, байршил	Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх
		-- СОНГОХ --
Шийдвэр, огноо	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо
	-- СОНГОХ --	
Тайлбар	Хамрагдах сав газрын нэр	
	-- СОНГОХ --	

Маягт А-03. Булаг, шандын бүртгэл

Д/д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- СОНГОХ --	-- СОНГОХ --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Булгийн нэр
-- СОНГОХ --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Булгийн горим	Устай эсэх төлөв (Өмнөх онд)
		-- СОНГОХ --
Устай эсэх төлөв (Тухайн онд)	Ундарга	pH
-- СОНГОХ --		
DO мг/л	EC, $\mu\text{S/cm}$	TDS, мг/л
t°C	Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх	Шийдвэр, огноо
	-- СОНГОХ --	
Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо	Эхийг хашиж хамгаалсан эсэх
-- СОНГОХ --		
Тайлбар	Хамрагдах сав газрын нэр	
	-- СОНГОХ --	

Маягт А-04. Рашааны бүртгэл

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- СОНГОХ --	-- СОНГОХ --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Рашааны нэр
-- СОНГОХ --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
H, м	Эмчилгээний төрөл	Төрөл
Устай эсэх төлөв (Өмнөх онд)	Устай эсэх төлөв (Тухайн онд)	Ундарга л/с
-- СОНГОХ --	-- СОНГОХ --	
Хэрэглээ м <sup>3</sup> /хон,	pH	DO мг/л
EC, µS/cm	TDS, мг/л	t <sup>0</sup> C
Рашааны нөөц баталгаажуулсан эсэх л/с	Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх	Шийдвэр, огноо
	-- СОНГОХ --	
Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо	Эхийг хашиж хамгаалсан эсэх
-- СОНГОХ --		
Эзэмшигчийн нэр	Холбоо барих утасны дугаар	Тайлбар
Хамрагдах сав газрын нэр		
-- СОНГОХ --		

Маягт А-05. Хөв, цөөрөм, усан сангийн бүртгэл

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- СОНГОХ --	-- СОНГОХ --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Усан сан, хөв, цөөрмийн нэр
-- СОНГОХ --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
H, м	Төрөл	Эх үүсвэр
Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Усан мандлын талбай, м <sup>2</sup>
pH	DO мг/л	EC, µS/cm
TDS, мг/л	t <sup>o</sup> C	Дундаж гүн, м
Өргөн, м	Урт, м	Эзлэхүүн, м <sup>3</sup>
Боомт, далангийн урт, м	Боомт, далангийн өргөн, м	Боомт, далангийн өндөр, м
Усаар хангах талбай, га	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо
	-- СОНГОХ --	
Тайлбар	Хамрагдах сав газрын нэр	
	-- СОНГОХ --	

**Маягт А-06 Худгийн бүртгэлийн маягт**

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- сонгох --	-- сонгох --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Худгийн төрөл
-- сонгох --		-- сонгох --
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Ашиглалтын зориулалт	Үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэл
	-- сонгох --	-- сонгох --
Худгийн паспортын дугаар	Зөвшөөрөлтэй эсэх	Ажилладаг эсэх
	-- сонгох --	-- сонгох --
Эрүүл ахуйн бүс тогтоосон эсэх	Шийдвэр, огноо	Барилгын хийц
-- сонгох --		-- сонгох --
Өрөмдсөн байгууллагын нэр	Өрөмдсөн Огноо	Худгийн гүн, м
Ундарга, л/с	pH	DO мг/л
EC, µS/cm	TDS, мг/л	t°C
Тоолууртай эсэх	Тоолуурын марк, хүчин чадал	Хоногийн дундаж ус ашиглалт, м³/хон
-- сонгох --		
Эзэмшигч иргэний нэр	Эзэмшигч ААНБ-ын нэр	Холбоо барих утас, хаяг
Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо	Тайлбар
-- сонгох --		
Хамрагдах сав газрын нэр		
-- сонгох --		

**Маягт А-06 Цооногийн бүртгэлийн маягт**

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- сонгох --	-- сонгох --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Цооногийн бүртгэлийн дугаар
-- сонгох --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Судалгааны зориулалт	Өрөмдсөн байгууллагын нэр
	-- сонгох --	
Өрөмдсөн огноо	Цооногийн гүн	Цооногийн диаметр
Цооногийн амсрын өндөр	Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж суурилуулсан эсэх	Багаж, тоног төхөөрөмжийн дугаар
Хэмжилтийн давтамж /жилд/	Сүүлд хэмжилт хийсэн огноо,	Хэмжилт хийх хугацааны давтамж /цаг/
Цооногийн паспортын дугаар	рН	DO мг/л
EC, $\mu\text{S}/\text{cm}$	TDS, мг/л	$t^{\circ}\text{C}$
Усны статик түвшин	Эзэмшигчийн нэр	Холбоо барих утас, хаяг
Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо	Тайлбар
-- сонгох --		
Хамрагдах сав газрын нэр		
-- сонгох --		

**Маягт А-07 Газрын доорх усны ордын маягт**

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- сонгох --	-- сонгох --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Ордын нэр
-- сонгох --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Ордын зориулалт зориулалт	Ордын талбай, м <sup>2</sup>
	-- сонгох --	
Батлагдсан нөөц, л/с	Нөөцийн зэрэглэл /А, В, С/	Огноо
	-- сонгох --	
Тушаалын дугаар	Тайлангийн бүртгэлийн дугаар	Гүйцэтгэсэн байгууллага
Захиалагч байгууллага	Судалгааны санхүүжилт	Ашиглалт, туршилтын худгийн тоо
Ажиглалтын цооногийн тоо	Одоогийн ашиглалтын хэмжээ, м <sup>3</sup> /хон	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх
		-- сонгох --
Бүртгэсэн огноо	Тайлбар	Хамрагдах сав газрын нэр
		-- сонгох --

Маягт А-08 Цэвэрлэх байгууламжийн бүртгэл

Д/д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- сонгох --	-- сонгох --
Баг, хороо	Эзэмшигч байгууллага	Цэвэрлэх байгууламжийн нэр
-- сонгох --		
Ашиглалтад орсон огноо	Хүчин чадал, м3/хон	Ажилладаг эсэх
		Тийм Үгүй /үгүй бол тайлбар хэсэгт бичих/
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Цэвэрлэх байгууламжийн төрөл	Цэвэрлэгээний арга
	-Ахуйн -Үйлдвэрийн	<p><b>Механик цэвэрлэгээ</b> -сараалж -элс баригч -тунгаагуур</p> <p><b>Биологи цэвэрлэгээ</b> -азротенк -биореактор -гүн цэвэрлэгээ</p> <p><b>Химийн арга</b> – холигч -реагентийн аж ахуй</p> <p><b>Физик-химийн арга</b>-реагентын цэвэрлэгээ -сорбци (шингээх) -экстракци (хандлах), -эвапораци (ууршуулах) -хийгүйжүүлэх, -ионы солилцоо - озонжуулах - цахилгаан флотаци (хөвүүлэх) -хлоржуулах -электродиализ (цахилгаан задрал)</p> <p><b>Электролитийн арга</b> <b>Флотацийн арга</b></p>
Хаягдал ус нийлүүлэх цэг	Шүүрүүлэх талбайн эзлэхүүн, м3	Биоцөөрмийн эзлэхүүн, м3
-- сонгох -- /гол-голын нэр, шүүрүүлэх талбай-тоо ширхэг, биоцөөрөм/		
Лагийн талбайн эзлэхүүн, м3	Тоолууртай эсэх	Тоолуурын марк, хүчин чадал
-- сонгох --	-- сонгох --	
Эзэмшигч иргэний нэр	Эзэмшигч ААНБ-ын нэр	Холбоо барих утас, хаяг
Бүртгэсэн огноо	Тайлбар	Хамрагдах сав газрын нэр
		-- сонгох --



**Маягт А-09 Услалтын системийн бүртгэл**

Д/д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- сонгох --	-- сонгох --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Услалтын системийн нэр
-- сонгох --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
Н, м	Толгойн барилга, боомт, гол болон дамжуулах сувгийн хийц, зохиомж, овор хэмжээ	Гол, хуваарилах сувгийн урт
Усалгааны тоног төхөөрөмжийн марк, тоо	Ус өргөх төхөөрөмжийн марк, тоо	Ашиглалтанд орсон огноо
Усны эх үүсвэр	Усны эх үүсвэрт тоолууртай эсэх	Хүчин чадал, га
Тарималын төрөл	Эзэмшигчийн нэр	Холбоо барих утас, хаяг
Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх	Бүртгэсэн огноо	Тайлбар
Хамрагдах сав газрын нэр		

**Маягт А-10 Үерийн хамгаалалтын далангийн бүртгэл**

Д/Д	Аймаг, Нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр
	-- сонгох --	-- сонгох --
Баг, хороо	Газар нутгийн нэр	Далан, сувгийн нэр
-- сонгох --		
Xd	Xm	Xs
Yd	Ym	Ys
H, м	Төгсгөл цэгийн газар нутгийн нэр	Далангийн сувгийн хийц, зохиомж
Ашиглалтанд орсон огноо	Далангийн урт, км	Сувгийн ёроолын өргөн, м
Сувгийн гүн, м	Эзэмшигчийн нэр	Холбоо барих утас, хаяг
Бүртгэсэн огноо	Тайлбар	Хамрагдах сав газар

Байгаль орчин, аялал жуулчлалын  
Сайдын 2023 оны ... дүгээр сарын ... -ны өдрийн  
А-... тоот тушаалын гуравдугаар хавсралт

Маягт № Б–01 Нуур, тойрмын дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сум, дүүргийн нэр	НИЙТ ТОО	Давхардаж тоологддог эсэх		Ангилал		Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах сав газрын нэр	Тухайн онд шинээр бүртгэгдсэн
			Тийм	Үгүй	Цэнгэг	Давстай	Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Маягт № Б–02 Нуур, тойрмын дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сав газрын захиргааны нэр	НИЙТ ТОО	Ангилал		Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах аймаг, нийслэл, сум, дүүрэг	Тухайн онд шинээр бүртгэгдсэн
			Цэнгэг	Давстай	Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогоогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр		
0	1	2	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Маягт № Б–03 Гол горхины дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сум, дүүргийн нэр	НИЙТ ТОО	Давхардаж тоологддог эсэх		Урсацын горим		Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах сав газрын нэр	Тухайн онд шинээр бүртгэгдсэн
			Тийм	Үгүй	Байнгын	Түр зуурын	Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогоогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Маягт № Б–04 Гол горхины дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сав газрын захиргааны нэр	НИЙТ ТОО	Урсацын горим		Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах аймаг, нийслэл, сум, дүүрэг	Тухайн онд шинээр бүртгэгдсэн
			Байнгын	Түр зуурын	Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогоогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр		
0	1	2	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Маягт № Б-05 Булаг, шандны дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сум, дүүргийн нэр	НИЙТ ТОО	Урсацын горим		Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах сав газрын нэр	Тухайн онд шинээр бүртгэгдсэн	Булгийн эхийг хашиж хамгаалсан эсэх	Тухайн онд булгийн эхийг хашиж хамгаалсан эсэх
			Байнгын	Түр зуурын	Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогоогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр				
0	1	2	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20

Маягт № Б–06 Рашааны дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сум, дүүргийн нэр	НИЙТ ТОО	Урсацын горим		Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах сав газрын нэр	Тухайн онд шинээр бүртгэгдсэн	Рашааны эхийг хашиж хамгаалсан эсэх	Тухайн онд рашааны эхийг хашиж хамгаалсан эсэх
			Байнгын	Түр зуурын	Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогоогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр				
0	1	2	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20



Маягт № Б-07 Усан сан, хөв цөөрмийн дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сум, дүүргийн нэр	НИЙТ ТОО	Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах сав газрын нэр	Тухайн онд шинээр бүртгэгдсэн
			Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогоогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр		
0	1	2	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Маягт № Б-08 Усан сан, хөв цөөрмийн дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сум, дүүргийн нэр	НИЙТ ТОО	Устай эсэх төлөв (Өмнөх онд)			Устай эсэх төлөв (Тухайн онд)			Хамгаалалтын бүс тогтоогдсон эсэх		Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах сав газрын нэр	Тухайн онд шинээр бүртгэгдсэн
			Устай	Тасарсан	Ширгэсэн	Устай	Тасарсан	Ширгэсэн	Тогтоосон	Тогтоогогүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр		
0	1	2	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Маягт № Б-09 Худгийн дэлгэрэнгүй тоон нэгтгэл

Д/Д	Сум, дүүргийн нэр	НИЙТ ТОО	Худгийн төрөл			Ашиглалтын зориулалт												Зөвшөөрөлтэй эсэх			Ажилладаг эсэх			Эрүүл ахуйн бүс тогтоосон эсэх		Барилгын хийц				
			Өрөмдмөл	Гар худаг	Мэдээлэлгүй	Унд ахуйн (Өрхийн)	Газар тариалан	Бэлчээрийн ус хангамж	Фермийн аж ахуй	Туслах аж ахуй	Аялал жуулчлал	Үйлдвэрлэл	Барилгын материал	Уул уурхай	Т.Т.А.Малмал	Ахуйн үйлчилгээ	Мэдээлэлгүй:	Зөвшөөрөлтэй:	Зөвшөөрөлгүй:	Мэдээлэлгүй:	Ашигладаг	Эвдэрсэн	Акталсан	Тогтоогдсон	Тогтоогдоогүй	Тоосго-блокон	Модон	Бетон	Барилгагүй	Мэдээлэлгүй
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30

Тоолууртай эсэх			Тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг эсэх		Хамрагдах сав газрын нэр	Тухайн онд шинээр бүртгэгдсэн
Тоолууртай	Тоолуургүй	Тодорхойгүй	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Орон нутгийн ТХГ-ын нэр		
31	32	33	34	35	36	37

Маягт № Б-010 САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ УСНЫ ТОО БҮРТГЭЛИЙН ТООН НЭГТГЭЛ

Д/Д	Сав газрын захиргааны нэр	Гол, горхи	Булаг шанд	Рашаан	Нуур, тойром	Баянбүрд	Мөстөл, мөсөн гол	Хиймэл нуур	Усан сан, хөв цөөрөм	Ус хангамжийн эх үүсвэрийн худаг	Худаг	Хяналт-шинжилгээний цооног	Услалтын систем	Үерийн хамгаалалтын далан, суваг	Усан цахилгаан станц	Цэвэрлэх байгууламж	Ус ашиглагч иргэн, ААН-ийн тоо	Ус хэрэглэгч иргэн, ААН-ийн тоо
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
<b>ДҮН</b>																		
<b>Шинээр нэмэгдсэн тоо:</b>																		
<b>Бүртгэлээс хасагдсан тоо:</b>																		

Маягт № Б-11 АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН УСНЫ ТОО БҮРТГЭЛИЙН ТООН НЭГТГЭЛ

Д/Д	Аймаг, нийслэлийн нэр	Гол, горхи	Булаг шанд	Рашаан	Нуур, тойром	Баянбүрд	Мөстөл, мөсөн гол	Хиймэл нуур	Усан сан, хөв цөөрөм	Ус хангамжийн эх үүсвэрийн худаг	Худаг	Хяналт-шинжилгээний цооног	Услалтын систем	Үерийн хамгаалалтын далан, суваг	Усан цахилгаан станц	Цэвэрлэх байгууламж	Ус ашиглагч иргэн, ААН-ийн тоо	Ус хэрэглэгч иргэн, ААН-ийн тоо	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	
<b>ДҮН</b>																			
<b>Шинээр нэмэгдсэн тоо:</b>																			
<b>Бүртгэлээс хасагдсан тоо:</b>																			

Маягт № Б-12 СУМ, ДҮҮРГИЙН УСНЫ ТОО БҮРТГЭЛИЙН ТООН НЭГТГЭЛ

Д/Д	Сум, дүүргийн нэр	Гол, горхи	Булаг шанд	Рашаан	Нуур, тойром	Баянбүрд	Мөстөл, мөсөн гол	Хиймэл нуур	Усан сан, хөв цөөрөм	Ус хангамжийн эх үүсвэрийн худаг	Худаг	Хяналт-шинжилгээний цооног	Услалтын систем	Үерийн хамгаалалтын далан, суваг	Усан цахилгаан станц	Цэвэрлэх байгууламж	Ус ашиглагч иргэн, ААН-ийн тоо	Ус хэрэглэгч иргэн, ААН-ийн тоо	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	
<b>ДҮН</b>																			
<b>Шинээр нэмэгдсэн тоо:</b>																			
<b>Бүртгэлээс хасагдсан тоо:</b>																			